

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/180/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: С.Цэрэнминжин
Утас: 89982722 Цахим хаяг:tseren8153@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
Аудитаар нийт 379.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг залрууллаа.....	14
5.1 Залруулсан алдаа	14
1. Нягтлан бодох бүртгэлийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалтад “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана” гэж заасны зөрчин 131.1 мянган төгрөгийн татварын өглөг дутуу илэрхийлсэн байсныг санхүүгийн тайланд тусгаж залруулга хийлгэсэн.	14
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална” гэж заасны зөрчин 248.0 мянган төгрөгийн зардлыг буруу илэрхийлсэн байсныг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН 11-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ДУЛАМСҮРЭН ТАНАА

2023.02.24 № УВА-2023/1801/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/500 дугаар тушаалаар өгөгдсөн чиглэлийн дагуу үйл ажиллагааны гүйцэтгэл чанар, үр дүнг үнэлж 3 багшид урамшуулал олгосон. Боловсрол, шинжлэх ухааны газрын хөрөнгө оруулалтаар 4322.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, 2885.7 хангамжийн материал ирсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200489

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>94,177,560.58</u>	<u>110,036,435.35</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	10,379,911.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	10,379,911.77
3121	Төгрөг	00.00	10,379,911.77
31211	Төрийн сангийн харилцах	00.00	10,379,911.77
33	АВЛАГА	14,205,297.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	205,297.00	00.00
335	Бусад авлага	14,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	14,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,972,263.58	99,656,523.58
351	Түүхий эд материал	00.00	225,500.00
35130	Эм боох материал	00.00	225,500.00
354	Хангамжийн материал	79,972,263.58	99,431,023.58
35460	Хүнсний материал	1,461,610.00	1,203,010.00
35470	Бусад хангамжийн материал	76,710,653.58	98,228,013.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,351,633,286.42</u>	<u>1,314,974,147.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,351,633,286.42	1,314,974,147.43
392	Биет хөрөнгө	1,351,248,286.33	1,314,809,147.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,390,969,000.00	1,390,969,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-77,676,952.08	-110,967,074.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,371,903.70	49,264,103.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,780,747.93	-22,303,655.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,490,626.98	11,990,426.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,637,544.34	-4,655,653.46
39217	Ном	512,000.00	512,000.00
393	Биет бус хөрөнгө	385,000.09	165,000.13
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-494,999.91	-714,999.87
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,445,810,847.00</u>	<u>1,425,010,582.78</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>131,070.91</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	131,070.91
413	Өглөг	00.00	131,070.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	131,070.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,445,810,847.00</u>	<u>1,424,879,511.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,445,810,847.00	1,424,879,511.87
512	Хуримтлагдсан үр дүн	1,445,810,847.00	1,424,879,511.87
51210	Өмнөх үеийн үр дүн	1,445,810,847.00	1,445,810,847.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-20,931,335.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,445,810,847.00</u>	<u>1,425,010,582.78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	411,624,522.05	494,262,460.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	386,854,038.24	7,807,760.00
120	Нийтлэг татварын бус орлого	343,138.24	7,807,760.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	343,138.24	7,807,760.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	600,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	386,510,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	386,510,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,770,483.81	486,454,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	433,598,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	433,598,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,540,483.81	52,856,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,540,483.81	52,856,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	428,953,830.25	515,193,795.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,953,830.25	515,193,795.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,142,417.82	506,628,773.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,350,839.89	326,234,129.82
210101	Үндсэн цалин	217,589,844.74	244,027,147.37
210102	Нэмэгдэл	21,179,002.36	60,144,511.27
210104	Урамшуулал	25,455,798.83	22,062,471.18
210105	Гэрээт ажлын хөлс	20,126,193.96	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,088,023.68	41,967,009.51
210201	Тэтгэврийн даатгал	25,183,395.68	28,635,157.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,793,871.25	3,393,254.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,162,847.35	2,665,590.11
210204	Ажилгүйдлийн даатгал	541,135.90	609,282.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,406,773.50	6,663,725.31

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,510,483.81	31,845,099.84
210301	Гэрэл, цахилгаан	5,689,533.81	8,700,102.84
210302	Түлш, халаалт	15,780,000.00	16,770,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,040,950.00	6,374,997.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,390,538.24	3,072,000.00
210401	Бичиг хэрэг	700,538.24	1,120,525.00
210402	Тээвэр, шатахуун	348,600.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	111,400.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	930,000.00	1,511,475.00
2105	Нормативт зардал	17,569,920.00	50,221,395.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,000.00	224,400.00
210502	Хоол, хүнс	17,474,920.00	49,996,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	388,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	388,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	604,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	604,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	1,178,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	378,000.00	746,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,822,612.20	51,119,138.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,020,000.00	5,768,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,802,612.20	44,051,138.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,811,412.43	8,565,021.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	8,522,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	8,522,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	42,721.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	42,721.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,011,412.43	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,011,412.43	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-17,329,308.20	-20,931,335.13
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-17,329,308.20	-20,931,335.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>411,281,383.81</u>	<u>487,054,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	411,051,383.81	600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,540,483.81	600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	600,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	386,510,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	386,510,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,000.00	486,454,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	433,598,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	433,598,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	52,856,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	52,856,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>411,281,383.81</u>	<u>476,674,788.23</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>411,281,383.81</u>	<u>476,674,788.23</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>397,469,971.38</u>	<u>468,109,766.26</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,520,333.89	325,897,761.91
210101	Үндсэн цалин	217,554,041.74	241,145,289.64
210102	Нэмэгдэл	21,384,299.36	62,268,161.01
210104	Урамшуулал	25,455,798.83	22,484,311.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,088,023.68	41,967,009.51
210201	Тэтгэврийн даатгал	25,183,395.68	28,635,157.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,793,871.25	3,336,014.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,162,847.35	2,665,590.11
210204	Ажилгүйдлийн даатгал	541,135.90	666,522.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,406,773.50	6,663,725.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,240,483.81	30,045,099.84
210301	Гэрэл, цахилгаан	5,689,533.81	8,700,102.84
210302	Түлш, халаалт	15,510,000.00	14,970,000.00

210303	Цэвэр, бохир ус	3,040,950.00	6,374,997.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,359,600.00	00.00
210401	Бичиг хэрэг	357,400.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	348,600.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	111,400.00	00.00
210404	Ном, хэвлэл	312,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,530,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,700,200.00	00.00
2105	Нормативт зардал	19,831,530.00	49,738,395.00
210502	Хоол, хүнс	18,936,530.00	49,738,395.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	746,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	378,000.00	746,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,020,000.00	19,415,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	14,960,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,020,000.00	4,455,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,811,412.43	8,565,021.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	8,522,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	8,522,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	42,721.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	42,721.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	10,379,911.77
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	10,379,911.77
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	10,379,911.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөг/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,483,007,805.32	1,483,007,805.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,483,007,805.32	1,483,007,805.32
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,867,650.12	-19,867,650.12

C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,445,810,847.00	1,445,810,847.00
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,445,810,847.00	1,445,810,847.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,445,810,847.00	1,445,810,847.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,366,451.41	-15,366,451.41
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,430,444,395.59	1,430,444,395.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	487,054,700.00	476,674,788,23	10,379,911.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	487,054,700.00	476,674,788,24	10,379,911.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468,109,766,26	468,109,766,26	0.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,897,761,91	325,897,761,91	0.00
210101	Үндсэн цалин	263,290,200.00	241,145,289,64	22,144,910.36
210102	Нэмэгдэл	61,557,700.00	62,268,161,01	710,461.01
210104	Урамшуулал	6,376,100.00	22,484,311,26	16,108,211.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,967,800.00	41,967,009,51	0.00
210201	Тэтгэврийн даатгал	28,627,100.00	28,635,157,50	-8,057.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,335,100.00	3,336,014,08	914.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,668,100.00	2,665,590,11	2,509.89
210204	Ажилгүйдлийн даатгал	667,300.00	666,522,51	3,574.69
210205	Эрүүл мэндийн даатгал	6,670,200.00	6,663,725,31	3,574.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,045,100.00	30,045,099,84	0.16
210301	Гэрэл, цахилгаан	12,000,100.00	8,700,102,84	3,299,997.16
210302	Түлш, халаалт	15,000,000.00	14,970,000.00	-30,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,045,100.00	6,374,997.00	3,329,897.00
2105	Нормативт зардал	54,573,000.00	49,738,395.00	-4,834,605.00
210502	Хоол, хүнс	54,573,000.00	49,738,395.00	-4,834,605.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	746,000.00	-216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	746,000.00	-216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19460500.00	19415500.00	-45,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,960,500.00	14,960,500.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,455,000.00	-45,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8522300.00	8522300.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,522,300.00	8,522,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,522,300.00	8,522,300.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	487,054,700.00	486,454,700.00	-600,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,598,300.00	433,598,300.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	433,598,300.00	433,598,300.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,856,400.00	52,856,400.00	0.00
132001	Орон нутгийн төсвөөс	52,856,400.00	52,856,400.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын 11-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролыг суралцагчдад эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр батлагдаж 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.

- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,094.2 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	10,379,9	10,379,9
Авлага	14,205,2	0	0
Бараа материал	79,972,2	99,656,5	19,684,3
Үндсэн хөрөнгө	1351633,2	1,320,539,0	-55,742,7
Нийт хөрөнгө	1,445,810,8	1,430,575,4	-31,094,2
Өр төлбөр	0	131,0	131,0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,445,810,8	1,430,575,4	-15,235,4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,445,810,8	1,430,575,4	-15,235,4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10,379.9 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 10,379.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны эхний үлдэгдэл нь 14,205.2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагыг бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99,656.5 мянган төгрөг болж 19,684.3 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн бусад хангамжийн материалаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,453,615.4 мянган төгрөг болж 15,253.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 4,072.1 мянган төгрөгийн хандив тусламжаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил ирсэн хэдий ч үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл нь 131.0 мянган төгрөг хувь хүний орлогын албан татварын өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,430,575.4 мянган төгрөг болж 15,253.3 мянган төгрөгөөр буурсан нь авлага буурч, өглөг үндсэн хөрөнгийн элэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн нь 1,430,575.4 мянган төгрөг болж өмнөх оны үр дүнгээс 1.05 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 519,672.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 519,672.9 мянган төгрөгөөр тооцон төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 519,672.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 434,198.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 85,474.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 434,198.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,856.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 423,818.3 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 10,379.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвийн 42,721.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	434,198.3	423,818.4	10,379.9	97.4%
2	Орон нутгийн үндсэн үйл ажиллагааны зардал	85,474.6	42,752.7	42,721.9	50%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 487,054.7 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 5,242.7 мянга, хүүхдийн хоолны зардлыг 4,834.6 мянга, гэрэл цахилгааны зардлыг 3,299.9 мянга, түлш халаалтын зардал 30.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, цэвэр бохир усны зардлыг 3,329.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Улаангом сумын 11-р цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын 11-р цэцэрлэг нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс аудит” ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс аудит” ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 428.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 509.6 сая төгрөгийн 1 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 145, хугацаа хоцроож 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Улаангом сумын 11-р цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаангом сумын 11-р цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 379.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг залрууллаа.

5.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалтад “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана” гэж заасны зөрчин 131.1 мянган төгрөгийн татварын өглөг дутуу илэрхийлсэн байсныг санхүүгийн тайланд тусгаж залруулга хийлгэсэн.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална” гэж заасны зөрчин 248.0 мянган төгрөгийн зардлыг буруу илэрхийлсэн байсныг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өглөг тусгаагүй	1	131.1	1	131.1			1	131.1				
Зардал буруу илэрхийлсэн	1	248,0			1	248,0	1	248,0				
Дүн	2	379.1	1	131.1	1	248,0	2	379.1				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“УВС ФИНАНС АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР 

/С.ЦЭРЭНМИНЖИН/

2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр